

Raffles
International Institute
Ulaanbaatar, Mongolia

Хөтөлбөр 2017/2018

Raffles Intern

 **northumbria**
UNIVERSITY NEWCASTLE

БАКАЛАВРЫН ЗЭРЭГ

Бизнес & Дизайн

**Их
Британийн
Бакалаврын
зэргийг
Монголдоо**

Бизнесийн Удирдлага
Хүний Нөөцийн Менежмент ба Манлайлал
Банк Санхүү
Интерьер Дизайн
График Дизайн

Рафлесийн Англи Хэлний Хөтөлбөр
Богино Хугацааны Сургалт
Өдөр, Орой, Бямбын Ангиуд



Вернон Сим

Рафлес Интернэшнл Институт
Сургуулийн Захирал



Майкл Левики

Рафлес Интернэшнл Институт
Академик Захирал

Эрхэм хүндэт оюутан залуус аа,

Баяр хүргэе!

Энэ танилцуулгыг уншиж байгаа тань ирээдүйгээ гэрэлтүүлэх нэг чухал шат юм. Боловсрол бол чиний гаргах ёстой хамгийн чухал шийдвэр бөгөөд амьдралд тань олон боломжуудын үүдийг нээж өгнө.

Рафлес Интернэшнл Институт (РИИ) бол дэлхийн хэмжээний “олон улсын” институт юм. Рафлес дэлхийн 13 орны 23 хотод 25 салбар сургуулиудтай ба Рафлесийн факультет дэлхийн 35 гаруй орноос ирсэн мэргэжлийн, туршлагатай олон улсын багш нараас бүрддэг. Эндээс олж авах боловсролын зэрэг тань дэлхийн хаана ч хүлээн зөвшөөрөгдөх болно.

Улаанбаатарчууд Чингэлтэй дүүрэгт орших манай сургуулийн улбар шар болон цагаан өнгийн хаяг бүхий байрыг 12 жилийн өмнөөс мэддэг болсон билээ.

Рафлес Интернэшнл Институт бусад сургуулиудаас юугаараа өөр, ямар онцгой давуу талуудыг таньд өгч болохыг энэхүү танилцуулгаас мэдэж аваарай.

Рафлес Боловсролын Корпораци

Рафлес Боловсролын Корпораци (Raffles Education Corporation Limited) нь Сингапурын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй хувьцаат компани юм. Тус корпораци нь дэлхийн 13 орны 23 хотод байрлах Рафлесийн 25 салбар сургуулиудыг эзэмшдэг ба үйл ажиллагааг нь удирдан явуулдаг. Рафлес Боловсролын Корпораци нь Их Британийн нэр хүндтэй их сургуулиудтай хамтран олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн боловсролын зэргийг оюутнууддаа санал болгодог.

1990 онд анхны коллежоо Сингапурт байгуулснаас хойш, Рафлес Боловсролын Корпораци улам бүр өргөжин тэлж, Бизнесийн удирдлага, Интерьер дизайн, График дизайн, Хувцас дизайн, Аялал жуулчлалын менежментээр Бакалаврын зэрэг олгох хөтөлбөрийг 20,000 гаруй оюутнуудад хүргэж байна.

Рафлес Боловсролын Корпорацийн амжилтын нууц нь маш чанд чанарын удирдлага, сүүлийн үеийн сургалтын програм болон практикт суурилсан дадлагын төсөл хөтөлбөрүүдэд нь байдаг.

Рафлес Групп таныг ирээдүйн карьерт тань бэлдэж, амжилтанд хүрэхэд тань туслах 2500 гаруй академик болон захиргааны ажилчидтай.

Рафлес Интернэшнл Институт Улаанбаатар Монгол Улс

Рафлес Интернэшнл Институт 2005 онд Улаанбаатарт үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш олон мянган оюутнуудад Бизнесийн Удирдлага, Интерьер дизайн, График дизайны болон Англи хэлний чиглэлээр чанартай боловсрол олгосон байна.

Рафлес Интернэшнл Институтийн академик факультет нь олон улсаас ирсэн чадварлаг гадаад багш нараас бүрдэх ба бүх хичээл Англи хэл дээр ордог. Манай оюутнууд төгсөхдөө мэргэжлийн Англи хэлтэй төгсдөг учраас гадна дотны шилдэг компани, аж ахуйн нэгжүүдэд ажилд орох боломжийг нээж өгдөг.

2017 онд Рафлес Интернэшнл Институт нь оюутнуудад зорилгодоо хүрэхэд нь туслах, сурах хүсэл эрмэлзлийг нь нэмэх, сүүлийн үеийн тоног төхөөрөмж бүхий тав тухтай шинэ байранд нүүж орохоор бэлтгэл ажлаа эхлүүлээд байна.

Холбоо барих:

Чингэлтэй дүүрэг, 5-р хороо,
Төмөрчний гудамж,
Улаанбаатар, Монгол Улс 211238

Утас : 328030 / 323663

www.raffles.mn

www.facebook.com/rafflesmg

E mail: admission@raffles-institute.edu.mn

Нортумбрия Их Сургууль нь Английн Ньюкастл хотод байрладаг бөгөөд дэлхийд тэргүүлэх судалгааны бааз, асар өргөн номын сангын сүлжээ болон мэргэжлийн байгууллагуудтай нягт хамтран ажилладаг зэргээрээ нэрд гарсан Их Британийн шилдэг их сургуулиудын нэг юм.

Нортумбрия Их Сургууль нь дэлхийн бизнесийн сургуулиудын топ 1%-д ордог бөгөөд

Мэргэжлийн Бизнесийн Сургуулиудын Холбоо (AACSB)-оор хоёр удаа магадлан итгэмжлэгдсэн.

Мөн Нортумбрия Их Сургууль нь оюутны сэтгэл ханамж болон төгсөгчидийн старт ап-аар Их Британидаа тэргүүлдэг.

2015 онд Нортумбрия Их Сургууль нь ажилд авахад хамгийн тохиромжтой дизайны төгсөгчид бэлддэг гэсэн жагсаалтын 2 дугаарт бичигдсэн байна.

Нортумбрия Их Сургууль дэлхийн бусад коллеж, институтуудтэй хамтран Их Британийн дээд боловсролыг тухайн орны оюутнуудад олгох хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

Рафлес Интернэшнл Институт болон Нортумбрия Их Сургуулийн хамтарсан хөтөлбөр нь Бизнесийн удирдлага - Менежмент, Хүний нөөцийн менежмент - Манлайлал, Банк санхүү гэсэн гурван мэргэжлээр бакалаврын зэрэг олгоно.

Энэ хамтарсан хөтөлбөр мөн Интерьер дизайн болон График дизайн гэсэн хоёр чиглэлээр бакалаврын зэрэг олгоно.

Бакалаврын хөтөлбөр нь нийт 36 сар үргэлжлэх ба дотроо 2 шаттай. Эхний шат 24 сар үргэлжлэх ба амжилттай төгссөн оюутнууд Сингапурын Рафлесаас Гүнзгий түвшний диплом гардан авна.

Эхний 24 сарын хөтөлбөрийг амжилттай төгссөн оюутнууд 2-р шат буюу Нортумбрия Их Сургуулийн Бакалаврын зэрэг олгох хөтөлбөрийг үргэлжлүүлэн судлана.

Амжилттай төгсөгчдөд зориулж төгсөлтийн ёслолыг Улаанбаатарт зохион байгуулж Их Британийн Бакалаврын диплом гардуулж өгнө. Төгсөгчид хүсвэл Английн Ньюкастл хотод очин Нортумбрия Их Сургуулийн төгсөлтийн ёслол дээрээс дипломоо гардан авч болно.

Нортумбрия Их Сургууль Ньюкастл Их Британи

Хамтарсан Хөтөлбөр

Рафлес Интернэшнл Институт-д суралцах шалтгаанууд:

- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн:** Та Рафлес Интернэшнл Институтыг төгсөөд үргэлжлүүлэн мастерт сурах болон карьераа эхлүүлэхэд таны бакалаврын зэргийг дэлхийн хаана ч хүлээн зөвшөөрөх болно. Үндэстэн дамнасан корпорациуд болон шилдэг их сургуулиуд таны дипломд эргэлзэхгүй.
- Давхар зэрэг:** Та эхний хоёр жилийн хөтөлбөрийг судлаад Сингапураас Гүнзгий түвшний диплом гардаж авах ба гуравдах жилийн хөтөлбөрөө судалж дууссаны дараа Их Британийн бакалаврын зэргээ авна.
- Англи хэл дээр бүх хичээл:** Бүх хичээл Англи хэл дээр орох учир сургуулиа төгсөх үед таны Англи хэл маш өндөр түвшинд хүрсэн байна.
- Олон Улсын факультет:** Олон улсаас ирсэн багш нараар хичээл заалгана гэдэг нь та юмыг олон талын өнцгөөс сурна гэсэн үг. Бизнес байна уу, дизайн байна уу энэ бүхнийг орон болгон өөр өөрөөр практикт хэрэглэдэг. Олон улсын, туршлагатай багш нараас суралцан олон давуу талуудыг өөртөө бий болго!
- Практиктай хосолсон сургалт:** Манай хөтөлбөрүүд онол дээр үзсэн зүйлсийг курсын ажил, бие даалт зэргээр бататгаад зогсохгүй бизнесийн байгууллагууд дээр дадлага хийх боломжийг бүрдүүлсэн. Төгсөөд ажил дээр гарахад шаардлагатай таны бүхий л ур чадваруудыг хөгжүүлэхэд бид анхаарах болно.
- Нэг зэргийг олон газраас:** Та сургуулиа Монголд эхэлж байгаа ч эхний хоёр жилийн хөтөлбөрийг судалж дуусгаад гурав дахь жилийн хөтөлбөрийг Нортумбрия Их Сургууль болон Рафлесийн бусад салбар сургуулиудад судлан төгсөж болно.

Яагаад Рафлес ЗӨВ СОНГОЛТ ВЭ?

Алтанхундагын Цолмонтаяа

Хавай Их Сургуулийн магистрант (МРА), АНУ
Бизнесийн Удирдлагын Бакалавр, Менежмент
2009 оны төгсөгч


“Рафлест суралцсан минь миний амьдралын хамгийн чухал үе байсан. Бүх хичээл нь Англиар орж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зэрэг олгодог нь эцэг эх минь энэ сургуулийг сонгоход ихээхэн нөлөө үзүүлсэн болов уу. Би төгсөөд Улаанбаатар дахь Дэлхийн Банкны Салбарт ажилласан. Бакалаврын түвшинд бүх хичээлээ Англи хэл дээр үзэж байсан минь намайг гадаадад мастерийн хөтөлбөрт тэнцэхэд минь нөлөөлсөн нэг гол үзүүлэлт байсан. Би Рафлесийн төгсөгч гэдгээрээ бахархдаг”.



Лхагвасүрэнгийн Солонго

Рафлес Дизайны Институт, Сингапур
Интерьер Дизайны Бакалавр
2016 оны төгсөгч


“Би Рафлес Дизайн Институтын төгсөгч мөн “Ай Эл Эс дизайн” компанийг үүсгэн байгуулагч. Би төгсөөд хагас жил хэртэй болж байгаа ч аль хэдийн гадаадын олон компаниуд дээр практик дадлага хийж, том жижиг янз бүрийн төсөл дээр ажилласан туршлагатай болсон байна. Рафлест сурсан нь ирээдүйн карьерын минь суурийг тавиад зогсохгүй ажил хэргийн хувьд чухал хүрээлэлд оруулж өгсөн гэж би боддог. Манай ангийнхан ч гэсэн нэр хүндтэй дизайны фирмүүдэд ажиллаж байна”.



Гантөмөрийн Батжаргал

Худалдан авалтын менежер, Очир Ундраа Групп
Бизнесийн Удирдлагын Бакалавр, Менежмент
2010 оны төгсөгч

“Рафлесаас олж авсан боловсрол, туршлага нь надад маш их хэрэг болсон. Очир Ундраа группын худалдан авалтын менежерийн хувьд би олон орноос ирсэн янз бүрийн хүмүүстэй хамтран ажиллах шаардлагатай болдог. Рафлесаас олж авсан чанартай боловсрол болон сургалтын хөтөлбөр, багш нар намайг ирээдүйн карьерт минь бэлдэж байсанд би талархдаг. Рафлес суралцах орчин нөхцлийг маш сайн бүрдүүлж өгдөг. Нэг багшид оногдох оюутны тоо цөөн учир багш нар оюутан бүртэй тулж ажилладаг. Рафлест суралцсан минь утга учиртай, маш үр дүнтэй туршлага болсон”.



Төгсөгчдийн амжилтын түүх

БАКАЛАВРЫН ЗЭРЭГ

1-р шат Гүнзгий түвшний диплом

Хөтөлбөрийн тойм: Рафлес Интернэшнл Институт нь оюутнуудад хамгийн сүүлийн үеийн бизнесийн туршлагаас суралцан улмаар олон улсын бакалаврын зэргийг хүртэх боломжийг олгодог. Оюутнууд эхний 2 семестерийн турш үндсэн хичээлүүдийг судлах ба үргэлжлүүлэн өөрсдийн сонгосон мэргэжлийн хичээлүүдийг сонгон судлах болно.

Рафлес Интернэшнл Институт Маркетинг, Менежмент, Банк Санхүү гэсэн 3 мэргэжлийн хөтөлбөрүүдийг санал болгодог.

Дадлага: Хоёр дахь жилдээ оюутнууд дадлагын хөтөлбөрт хамрагдана. Дадлагаа банк, санхүүгийн байгууллагууд, даатгал, ложистик, иргэний нисэх, хоол, ундаа, худалдаанаас гадна Монголын эдийн засгийн бусад салбарт хийх боломжтой.

- Хөтөлбөрийн давуу талууд:**
- Оюутнууд хоёр олон улсын зэрэг авна:
 1. Гүнзгий түвшний диплом (Рафлес Сингапур)
 2. Бакалаврын зэрэг (Нортумбрия Их Сургууль, Их Британи)
 - Олон Улсын Бизнесийн Хөтөлбөр (Маркетинг, Менежмент, Банк Санхүү)
 - Гурав дахь жилдээ Менежмент, Хүний Нөөцийн Менежмент, Банк Санхүүгээр мэргэших
 - Төгсөхдөө Бизнесийн Англи хэлтэй төгсөх
 - Олон улсын тэргүүлэх хөтөлбөр
 - Өдөр, орой, бямбын ангиуд

- Яагаад манай бакалаврын зэрэг гэж:**
- Гурван жилийн эрчимжүүлсэн сургалт
 - Жилд 4 удаа элсэлт авдаг
 - Монголын шилдэг аж ахуйн нэгжүүдэд дадлага хийх боломж
 - Бүх хөтөлбөр Англи хэл дээр орох тул дэлхийн бизнесийн ертөнцтэй хөл нийлүүлнэ
 - Хаанаас ч сурч болох онлайн сургалтын систем

Бизнесийн Удирдлага

Үндсэн Хичээлүүд:

- Эдийн засгийн онол
- Нягтлан бодох бүртгэлийн онол
- Бизнесийн харилцаа 1
- Маркетингийн үндэс
- Бизнесийн харилцаа 2
- Менежмент ба байгууллагын зан төлөв
- Бизнесийн статистик
- Бизнесийн мэдээллийн систем
- Хүний нөөцийн Удирдлага
- Шийдвэр гаргалтийн нягтлан бодох бүртгэл, санхүү
- Харилцагчийн үйлчилгээний менежмент
- Корпорацийн харилцаа
- Үйл ажиллагаа ба чанарын удирдлага
- Банк санхүүгийн үндэс
- Маркетингийн судалгаа
- Стратегийн менежмент
- Дадлага – Үйлдвэрлэл дээрх сургалт
- Курсын ажил

Бакалаврийн хөтөлбөрийн бэлтгэл хичээл

Академик эссэ ба академик судалгаа: Энэ хоёр хичээл нь оюутнуудыг бакалаврын түвшинд диплом бичих, судалгаа хийхэд бэлтгэх зорилготой. Хичээлүүд 10 долоо хоногын турш зэрэгцэн орно.

Мэргэжлийн хичээлүүд:

Оюутнууд сонгосон мэргэжлийн хэсгээс 4 хичээл сонгож судлана:

Маркетинг

Маркетингийн Удирдлага

Корпорацийн айдентик ба бренд менежмент

И-маркетинг

Маркетингийн төлөвлөгөө

Бизнесийн хууль

Олон улсын маркетинг

Менежмент

Маркетингийн менежмент

Корпорацийн ... ба брендийн менежмент

Харьцуулсан менежмент

Манлайлал ба нийгмийн хариуцлага

Хэлэлцээ хийх ба асуудал шийдвэрлэх

Бизнесийн хууль

Банк санхүү

Хөрөнгө оруулалтын анализ

Банкны үйл ажиллагаа ба эрсдлийн шинжилгээ

Олон улсын санхүүгийн зах зээл

Банкны хууль ба олон улсын банк санхүү

Корпорацийн санхүү

Удирдлагын эдийн засаг

БАКАЛАВРЫН ЗЭРЭГ

2-р шат Рафлес-Нортумбриа Хамтарсан Хөтөлбөр

Мэргэжил: Бизнесийн Менежмент

Хөтөлбөрийн тойм: Нортумбриа Их Сургуулийн Бизнесийн Удирдлагын бакалаврын зэрэг олгох хөтөлбөр нь оюутнуудад бодит туршлага суулгах хамгийн сүүлийн үеийн судалгаа, бизнес практик, техник дээр суурилдаг. Улсын болон хувийн хэвшлийн салбарийг бүхэлд нь хамарсан удирдах албан тушаалтнуудыг бэлтгэн гаргадаг.

Энэ чиглэлээр төгсөгчид үргэлжлүүлэн Бизнесийн Удирдлагаар мастерт (MBA) сурах эсвэл бизнесийн болон төслийн менежментийн чиглэлээр ажиллана.

Мэргэжил: Хүний Нөөцийн Удирдлага ба Манлайлал

Хөтөлбөрийн тойм: Нортумбриа Их Сургуулийн Хүний Нөөцийн Удирдлагын бакалаврын зэрэг олгох хөтөлбөр нь төгсөгчдийг бизнесийн болон төрийн байгууллагуудын хүний нөөцийн хэлтэст ажиллах болон түүнийг удирдах чадвар бүхий хүний нөөцийн менежерүүд болгох зорилготой.

Энэ чиглэлээр төгсөх оюутнууд үргэлжлүүлэн мастерт сурах эсвэл хүний нөөцийн менежментийн чиглэлээр ажиллана.

Мэргэжил: Банк санхүү

Хөтөлбөрийн тойм: Нортумбриа Их Сургуулийн Банк Санхүүгийн бакалаврын зэрэг олгох хөтөлбөр нь хамгийн сүүлийн үеийн практик болон олон улсын түвшин дэхь банк санхүүгийн салбарын ноу-хау дээр суурилдаг. Оюутнууд дэлхийн банк санхүүгийн ертөнцөд санхүүгийн байгууллагууд хэрхэн үйл ажиллагаагаа явуулж, хэрхэн зохион байгуулагдаж байгаа талаар үндсэн ойлголт авна. Энэхүү хөтөлбөр нь оюутнуудыг банк санхүүгийн салбарт ажиллах болон үргэлжлүүлэн санхүүгийн чиглэлээр мастерт сурахад нь бэлдэх болно.

Бизнесийн Удирдлага

Сургалтын хөтөлбөр:

Судалгаанд суурилсан сургалт ба практик

Манлайлал

Стратегийг ойлгох нь

Ажил ба Байгууллагыг дахин шинэчлэх нь

Орчин үеийн Корпорацийн Тайлан

Судалгааны ажил

Ажил, мэргэжлийн боломжууд:

- Маркетингийн менежер
- Бизнесийн менежер
- Борлуулалтын менежер
- Ложистикийн менежер

Сургалтын хөтөлбөр:

Судалгаанд суурилсан сургалт ба практик

Манлайлал

Стратегийг ойлгох нь

Ажил ба Байгууллагыг дахин шинэчлэх нь

Хүний нөөц ба хөгжүүлэлт

Судалгааны ажил

Ажил, мэргэжлийн боломжууд:

- Хүний нөөцийн мэргэжилтэн
- Хүний нөөцийн менежер
- Хүний нөөцийн баг бүрдүүлэгч
- Сургалтын менежер

Сургалтын хөтөлбөр:

Судалгаанд суурилсан сургалт ба практик

Манлайлал

Стратегийг ойлгох нь

Банкны эрсдэл 1

Банкны эрсдэл 2

Судалгааны ажил

Ажил, мэргэжлийн боломжууд:

- Банкны менежер
- Хөрөнгийн менежер
- Compliance manager
- Санхүүгийн менежер

БАКАЛАВРЫН Зэрэг

1-р шат Гүнзгий түвшний дипломын хөтөлбөр

Хөтөлбөрийн тойм: Рафлес Интернэшнл Институт нь оюутнуудад Интерьер Дизайний үндсэн болон ахисан түвшний мэдлэгийг олгох хөтөлбөрийг санал болгож байна. Эхний хоёр жилийн турш оюутнууд хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмж болон арга барилыг ашиглан төрөл бүрийн интерьер дизайныг хийж сурна. Гурав дахь жилийн хөтөлбөр нь бакалаврын зэрэг олгох илүү дээд түвшний судалгаа ажил болон мэргэжлийн төсөл дээр ажиллах хөтөлбөрийг өөртөө багтаасан.

Хөтөлбөрийн давуу тал:

- Оюутнууд олон улсын хоёр зэрэг авна:
 1. Гүнзгий түвшний диплом (Рафлес, Сингапур)
 2. Бакалаврын зэрэг (Нортумбрия Их Сургууль, Их Британи)
- Олон улсын зэрэгтэй дизайнеруудийн багтай хамт суралцах
- Интерьер дизайныг Англи хэл дээр сурснаар оюутнууд төгсөөд дотоод, гадаадын дизайны шилдэг фирмүүдэд ажиллах боломж нээгдэнэ
- Өдөр, орой, бямбын анги

Яагаад манай бакалаврын зэрэг гэж?

- Гурван жилийн эрчимжүүлсэн сургалт
- Жилд 4 удаа элсэлт авдаг
- Монголын шилдэг компаниудад дадлага хийх боломж
- Олон Улсаас ирсэн шилдэг багш нар
- Бүх хөтөлбөр Англи хэл дээр орох тул дэлхийн дизайны ертөнцтэй хөл нийлүүлнэ

2-р шат Рафлес-Нортумбрия Хамтарсан Хөтөлбөр

Хөтөлбөрийн тойм: Нортумбрия Их Сургуулийн Интерьер дизайны Бакалаврын зэрэг олгох хөтөлбөр нь Европдоо шилдэгт тооцогддог дизайны хөтөлбөр бөгөөд Улаанбаатар хот дахь Рафлес Интернэшнл Институт дээр хэрэгжиж байна.

Энэхүү бакалаврын хөтөлбөр нь модулын системээр явагддаг ба 12 сарын турш үргэлжлэнэ. Улаанбаатар дахь Рафлес Интернэшнл Институт дээр бүх хөтөлбөрийг заана.

Интерьер Дизайн

Үндсэн хичээлүүд:

Нэг дэхь жил:

Интерьер дизайны үндэс ба онол

Гар зураг

Архитектурын драфт

Интерьерийн өнгөний сонголт

Компьютер График

Презентацийн зураг I

Соёл Судлал

Бүтээлч байдал болон консепт хөгжүүлэлт

Презентацийн зураг II

2D компьютер-тусламжтай-зурах

Интерьерийн материал

3D компьютер-тусламжтай-зурах / REVIT

Дизайн Студи I – Орон сууц

Барилгын технологи ба барилга угсралт

2 дахь жил:

Дизайн студи II – Худалдаа, Үйлчилгээ

Барилга судлал I

Компьютер рендер ба Анимейшн

Тавилгын түүх, дизайн, хэрэглээ

Дизайн студи III – Оффис

Орчны гэрэлтүүлэг

Барилга судлал II

Судалгааны ажил ба харилцааны чадвар

Дизайн студи IV – Зочид буудал, ресторан

Төсөв, Өртөг тооцолт, бичиг баримт

Бүтээлийн цуглуулга (Портфолио)

Дадлагын ажил

Үйлдвэрийн хэрэглээ

Мэргэжлийн хичээлүүд:

3 дахь жил:

Худалдааны Интерьер дизайн

Дизайны санал

Ахисан түвшний Интерьер дизайны практик (Хөгжүүлэлтийн)

Ахисан түвшний Интерьер дизайны практик (Үйлдвэрийн)

Интерьер дизайны мэргэжлийн дадлага

Ажил, мэргэжлийн боломжууд:

- Интерьер дизайнер
- Тавилгын дизайнер
- Худалдааны талбайн дизайнер
- Чимэглэлийн дизайнер
- Бүтээгдэхүүний дизайнер
- Төсөл хөгжүүлэгч
- Бренд менежер

БАКАЛАВРЫН Зэрэг

1-р шат Гүнзгий түвшний диплом

Хөтөлбөрийн тойм: Оюутнууд эхний 2 жилийн турш график дизайны үндсэн болон ахисан түвшний элементүүд, зарчмууд, салбарын сүүлийн үеийн технологи, стратегийг лекц, воркшоп, дадлага ажил, төсөл зэргээр дамжуулан суралцана.

3 дахь жилийн хөтөлбөр нь бакалаврын зэрэг горилох судалгааны ажил, дипломын ажил зэргийг багтаасан цогц хөтөлбөр байна.

- Хөтөлбөрийн давуу тал:**
- Оюутнууд олон улсын хоёр зэрэг авна:
 1. Гүнзгий түвшний диплом (Рафлес, Сингапур)
 2. Бакалаврын зэрэг (Нортумбрия Их Сургууль, Их Британи)
 - Олон улсын зэрэгтэй дизайнеруудийн багаар хичээл заалгах
 - График дизайныг Англи хэл дээр сурснаар оюутнууд төгсөөд дотоод, гадаадын дизайны шилдэг фирмүүдэд ажиллах боломж нээгдэнэ
 - Өдөр, орой, бямбын анги

Яагаад манай бакалаврын зэрэг гэж?

- Гурван жилийн эрчимжүүлсэн сургалт
- Жилд 4 удаа элсэлт авдаг
- Монголын шилдэг компаниудад дадлага хийх боломж
- Олон Улсаас ирсэн шилдэг багш нар
- Бүх хөтөлбөр Англи хэл дээр орох тул дэлхийн дизайны ертөнцтэй хөл нийлүүлнэ

2-р шат Рафлес-Нортумбрия Хамтарсан Хөтөлбөр

Хөтөлбөрийн тойм: Нортумбрия Их Сургуулийн График дизайны Бакалаврын зэрэг олгох хөтөлбөр нь Европдоо шилдэгт тооцогддог дизайны хөтөлбөр ба Улаанбаатар хот дахь Рафлес Интернэшнл Институт дээр хэрэгжиж байна.

Энэхүү бакалаврын хөтөлбөр нь модулын системээр явагддаг ба 12 сарын турш үргэлжлэнэ. Рафлесын кампус дээр бүх хөтөлбөрийг заана.

График Дизайн

Үндсэн хичээлүүд:

Нэг дэхь жил:

Дизайны зураглал

Бүтээлч сэтгэлгээ ба төсөөлөх чадвар хөгжүүлэлт

Дизайны үндэс

Дизайны өнгө шийдэл

Дизайн түүх ба соёл

Типографикийн үндэс

Дижитал зураг боловсруулалт

Дижитал гэрэл зураг

Судалгааны ажил ба харилцааны чадвар

Ерөнхий зураглал

Дижитал зураг ба иллюстраци

Хэвлэмэл бүтээгдэхүүн

Байгууллагын айдентик

Сав баглаа боодлын дизайн

Хоёр дахь жил:

Медиа дизайн

Ахисан түвшний зураглал ба үйлдвэрлэл

Ахисан түвшний Типографик

Веб дизайны үндэс

Хэвлэмэл бүтээгдэхүүний дизайн

Зар сурталчилгааны дизайны зарчмууд

Бие даалтын ажил

Бүтээлийн цуглуулга I (Портфолио)

Дизайн студи I – Дизайны ажил

Үйлдвэрийн дадлага

Дизайн студи II – Дизайны ажил

Бүтээлийн цуглуулга II (Портфолио)

Мэргэжлийн хичээлүүд:

Гурав дахь жил:

График дизайны туршилтын болон хамтарсан брендинг

График дизайны төгсөлтийн ажил (Брендинг)

График дизайны хамтарсан брендинг

Дизайны тайлан

Ажил, мэргэжлийн боломжууд:

- Бүтээлч захирал
- Иллюстратор, зураач
- Сав баглаа боодлын дизайнер
- Бүтээгдэхүүний дизайнер
- Мэргэжлийн гэрэл зурагчин
- Мультимедиа мэргэжилтэн

Рафлесийн Англи Хэлний Хөтөлбөр

Хөтөлбөрийн тойм:

Рафлесийн Англи хэлний хөтөлбөр нь Азийн хамгийн шилдэг хэлний хөтөлбөрүүдийн нэгээр үнэлэгддэг. Өнгөрсөн 10 гаруй жилийн турш дэлхийн жишигт хүрсэн сургалтын чанарыг хүргэхийн тулд олон улсын зэрэгтэй чадварлаг багш нар (100% гадаад) Рафлесийн Англи хэлний хөтөлбөрийг удирдан явуулж байна.

Орчин үеийн сургалтын тоног төхөөрөмж бүхий тав тухтай, цэвэрхэн, саруулхан анги танхимууд таны суралцах нөхцлийг бүрэн хангана. Рафлесийн Англи хэлний хөтөлбөр нь оюутнуудын дүрэм, сонсгол, бичих ур чадвар, унших, ярианы чадварыг хөгжүүлэх идэвхтэй, өндөр үр дүнтэй аргыг сургалтандаа нэвтрүүлсэн.

Сургалтын загвар:

Рафлесийн Англи хэлний хөтөлбөр (REP) дотроо 6 үндсэн түвшинтэй. Оюутнууд түвшин тогтоох шалгалт өгч өөрт тохирсон түвшний ангидаа элсэнэ.

Оксфордын албан ёсны түвшин тогтоох шалгалтаар таны түвшинг тогтоож өгнө

Яагаад Рафлесийн Англи хэлний хөтөлбөр гэж?

- Тав тухтай найрсаг орчинд 100% гадаад багшаар заалгана
- Аудио, видео зэрэг нэмэлт хэсгүүдээс бүрдсэн хамгийн сүүлийн үеийн сургалтын материал
- Өглөө, оройн ангиудаас сонголтоо хийх
- Өөрийнхөө ахицыг мэдэх явцын шалгалтууд
- Түвшин 6-г төгсөөд Англиар чөлөөтэй харилцдаг болох

Байгууллагад зориулсан Англи хэлний хөтөлбөр:

Рафлес Интернэшнл Институт нь Монголд үйл ажиллагаагаа явуулж буй байгууллага, аж ахуйн нэгжүүдэд Англи хэлний тусгай хөтөлбөрийг санал болгож байна. Энэхүү хөтөлбөрийг танай байгууллага дээр өглөө, өдөр, оройн аль тохиромжтой цагт явуулах боломжтой.

Бүрдүүлэх материал:

- Оксфордын түвшин тогтоох шалгалтын оноо
- Рафлес Интернэшнл Институтын Элсэлтийн өргөдөл

Элсэлт авах сарууд:

Рафлесийн Англи хэлний хөтөлбөр жилд 4 удаа элсэлт авдаг: 1, 4, 7, 10-р саруудад. (Байгууллагад зориулсан Англи хэлний хөтөлбөрт хамаарахгүй)



АНГЛИ ХЭЛНИЙ ХӨТӨЛБӨР

Зургаан түвшний сургалт:

Түвшин 1 – Анхан шат

Англи хэлийг эхлэн суралцагсдад зориулсан хэлний үндсэн бүтэц, үгийн сангийн мэдлэгийг өргөжүүлэх суурьтай анхан шатны сургалт. Суралцагсдын Англи хэлний суурь мэдлэгийг бэхжүүлж үргэлжлүүлэн сурахад бэлтгэнэ.

Түвшин 2 – Анхан дунд шат

Энэ түвшин нь анхан шатанд үзсэн суурь хичээлүүд дээр үндэслэн үргэлжлүүлэн оюутнуудын дүрэм, үгсийн сан, унших, бичих дадлыг хөгжүүлж Англиар чөлөөтэй харилцах суурийг тавьж өгнө.

Түвшин 3 – Дунд шат

Өдөр тутмын амьдралд хэрэглэгдэх харилцааны болон бичгийн ур чадварыг хөгжүүлнэ. Энэ шатны хөтөлбөр нь олон орны соёлыг судлан, гадаад оронд аялах, амьдрах, сурах зэрэг тохиолдлуудад хэрэглэгдэх Англи хэлийг үзнэ.

Түвшин 4 – Ахисан дунд шат

Хэлзүйн цогц бүтэц, үгийн сангийн байлагтай болсноор өөрийн санаа бодлоо чөлөөтэй илэрхийлдэг болно. Текстийн гол агуулгыг ойлгож унших, текст бичих, чөлөөтэй ярьж чаддаг болно.

Түвшин 5 – Гүнзгий шат

Бичих ур чадвараа сайжруулж ахисан түвшний дүрмүүд үзнэ. Энэ шатыг амжилттай дүүргэснээр онолын хүрээнд эссэ бичих, текст уншаад дүгнэлт хийх чадвар эзэмшинэ.

Түвшин 6 – IELTS шалгалтын хөтөлбөр

IELTS шалгалтыг амжилттай өгөх, хүссэн оноогоо авахад шаардлагатай арга барил, дадал техникийг эзэмшүүлнэ. IELTS-ийн үндсэн 4 хэсэг болох ярих, сонсох, унших, бичих чадварыг гүнзгий түвшинд олгоно.

ЦАГ МӨНГӨӨ ХЭМНЭ

78%

хүртэл

ХЭМНЭ

Рафлес Интернэшнл Институт-д сурснаар хичнээн их мөнгө хэмнэж чадахаа мэдвэл энд сурах нь хамгийн ухаалаг шийдвэр гэдгийг та мэдэх болно!

Цагаа хэмнэ!

Монголын их дээд сургуулиуд ихэвчлэн 4 жилийн хөтөлбөр санал болгодог. Рафлес – Нортумбриагын хамтарсан хөтөлбөр нь 3 жилийн дотор танд бакалаврын зэрэг олгоно. Энэ нь та дотоодын их дээд сургуульд сурч буй үеийнхнээсээ нэг жилийн өмнө төгсөнө гэсэн үг.

Мөнгөө хэмнэ!


Та үеийнхнээсээ нэг жилийн өмнө ажил хийж эхлэх болохоор нэг жилийн цалин илүү олж авна.

Рафлес Олон Улсын Институт-д 3 жил сурах сургалтын төлбөр ойролцоогоор 67 сая төгрөг болно. Та нарын ихэнх тань гэрийнхэнтэйгээ амьдардаг учраас сард ойролцоогоор 400,000 төгрөгийг хоол, тээврийн хэрэгсэлд зарцуулна гэж үзвэл 3 жилийн турш 81 сая төгрөгөөр Их Британийн Бакалаврын зэрэгтэй төгсөх болно (34,000 ам.доллар).

Их Британид сурна гэвэл жилийн ойролцоогоор 10,000 фунт сургалтын төлбөрт төлнө. Амьдрах өртөг нь дундажаар сарын 1000 фунт гэж үзвэл нийт 66,000 фунтыг (85,000 ам.доллар) зарцуулж байж Их Британийн бакалаврын зэрэгтэй төгсөнө.

Америкийн Бакалаврын зэрэг бол жилд 40,000 ам.доллар орчим төлнө гэж үзвэл 4 жил сурахад 160,000 ам доллар болно.

Бакалаврын зэргийн өртөг (USD)



МЭРГЭЖИЛ ХӨГЖЛИЙН ТӨВ

Ур чадвараа хөгжүүлэхийг хүссэн ч цаг завгүйгээсээ болоод чаддаггүй мэргэжилтнүүдэд зориулсан хариулт бидэнд байна.

Манай олон улсын мэргэжилтэй багш нар маш нягт, цэгцтэй сургалтын хөтөлбөрүүдээс зөвхөн танай байгууллагын онцлогт тохируулсан мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх 1-2 өдрийн хөтөлбөрийг боловсруулан гаргах боломжтой.

Энэхүү сургалтыг 20 хүртэлх хүнтэйгээр өөрийн болон тухайн байгууллагын байранд зохион байгуулна. Сургалтыг мэргэжлийн гадаад багш удирдан явуулна.

Байгууллагуудын хувьд 10-аас доош хүнтэй жижиг групп сургалтыг манай багш нар байгууллаг дээр очин зардал багатайгаар явуулах боломжтой.

Зарим байгууллагууд өөрсдийнхөө сургалтыг явуулах тав тухтай, сүүлийн үеийн тоног төхөөрөмж бүхий сургалт хийх газар хайж байвал Рафлес та бүхнийг шаардлагыг хангах саруулхан анги танхимуудыг санал болгож байна.

Бидэнтэй холбогдож асуудлаа шийдээрэй.

Орой, Бямбын Ангиуд

Англи хэл болон ур чадвараа сайжруулах, боловсролын зэргээ ахиулахыг хүссэн завгүй мэргэжилтнүүдэд зориулсан хөтөлбөрийг Рафлес санал болгож байна.

Бид зөвхөн оройгоор болон бямба гарагуудад хичээллэдэг дипломын зэрэг олгох ангиуддаа ажил хийдэг хүмүүсийг урьж байна.

Ажиллангаа
сур!

Raffles
International Institute
Ulaanbaatar, Mongolia

Chingetei District, 5th Khoroo,
Tumurchny Street,
Ulaanbaatar, Mongolia 211238

T : 328030 / 323663

admission@raffles-institute.edu.mn

www.raffles.mn

www.facebook.com/rafflesmgi

www.raffles-education-corporation.com